



МОНГОЛ УЛС ШАДАР САЙДЫН ТУШААЛ

2016 оны 9 дугаар
сарын 08 -ны өдөр

Дугаар 98

Улаанбаатар
хот

Үйл ажиллагааны стратеги, зохион
байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн
хөтөлбөрийг шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэг, Засгийн газрын 2016 оны 4 дүгээр тогтоол "Засгийн газрын агентлагийн талаар авах зарим арга хэмжээний тухай"-ыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Засгийн газрын тохируулагч агентлаг – Стандарт, хэмжил зүйн газрын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийг нэгдүгээр, зохион байгуулалтын бүтцийг хоёрдугаар хавсралтаар тус тус шинэчлэн баталсугай.

2. Засгийн газрын агентлагийн орон тооны хязгаарт багтаан үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн дагуу албан хаагчдыг зөв зохистой байршуулах, зохион байгуулалтын арга хэмжээ авч, хөтөлбөрийг хэрэгжүүлж ажиллахыг Стандарт, хэмжил зүйн газрын дарга /Г.Гантөмөр/-д даалгасугай.

3. Энэ тушаал гарсантай холбогдуулан Монгол Улсын Шадар сайдын 2015 оны 2 дугаар тушаалыг хүчингүйд тооцсугай.

Монгол Улсын Шадар сайд



У.ХҮРЭЛСҮХ

СТАНДАРТ, ХЭМЖИЛ ЗҮЙН ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ СТРАТЕГИ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН БҮТЦИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ХӨТӨЛБӨР

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Оршил

Засгийн газрын тохируулагч агентлаг-Стандарт, хэмжил зүйн газар (цаашид "газар" гэх)-ын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр /цаашид "хөтөлбөр" гэх/-ийн зорилго нь Монгол Улсын Шадар сайдын эрхлэх асуудлын хүрээнд стандартчилал, тохирлын үнэлгээ (итгэмжлэл, баталгаажуулалт, сорилт, техникийн хяналт), хэмжил зүй, сорьцын хяналтын хууль эрх зүйн орчинг боловсронгуй болгох, бодлого, хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулах, төлөвлөгөөг хэрэгжүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах, зохицуулах, хяналт-шинжилгээ хийх, үнэлгээ өгөх зэрэг асуудлыг хамарсан стратеги болон бүтцийн загварыг тодорхойлоход оршино.

1.2. Үндэслэл

Энэ хөтөлбөрийг Монгол Улсын Засгийн газрын тухай хууль, Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хууль болон Улсын Их Хурлын 1996 оны 05 дугаар сарын 21-ны өдрийн 38 дугаар тогтоолоор зөвшөөрсөн "Монгол Улсын төрөөс Засгийн газрын үйл ажиллагааны чиглэл, бүтцийн ерөнхий тогтолцооны өөрчлөлт, шинэчлэлийн талаар баримтлах бодлого"-ын баримт бичиг, холбогдох хууль тогтоомжуудыг тус тус үндэслэн боловсруулав.

1.3 Хууль, эрх зүйн орчин

Хөтөлбөрийг дор дурдсан хууль тогтоомжийн хүрээнд хэрэгжүүлнэ.

- Монгол Улсын Үндсэн хууль;
- Монгол Улсын Засгийн газрын тухай хууль;
- Монгол Улсын Төрийн албаны тухай хууль;
- Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хууль;
- Төсвийн тогтвортой байдлын тухай хууль
- Төсвийн тухай хууль;
- Стандартчилал, тохирлын үнэлгээний тухай хууль;
- Хэмжлийн нэгдмэл байдлыг хангах тухай хууль;
- Төрийн хяналт шалгалтын тухай хууль;
- Хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах тухай хууль;
- Ашигт малтмалын тухай хууль;
- Шилэн дансны тухай хууль;
- Бусад хууль тогтоомж.

1.4 Арга зүй

Хөтөлбөрийг боловсруулахдаа олон улсын зөвлөмж, гадаад орнуудын байгууллагын өөрчлөлтийн удирдлага, үйл ажиллагаа (бизнес)-ны төлөвлөлт болон дахин инженерчлэлийн арга зүй, Засгийн газар, яам, агентлагуудын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрүүд, түүнчлэн стандартчилал, тохирлын үнэлгээ, хэмжил зүй, сорьцын хяналтын салбарт хуримтлагдсан олон улсын туршлага, нийтлэг жишгийг ашиглав.

1.5 Газрын үүрэг, хариуцлагын ерөнхий хуваарь

Газар нь Засгийн газрын үйл ажиллагааны стандартчилал, тохирлын үнэлгээ, хэмжил зүй, сорьцын хяналтын бодлогыг боловсруулах, хэрэгжүүлэх үүрэг, хариуцлага хүлээж Монгол Улсын Шадар сайдад зөвлөгөө, бүх талын дэмжлэг үзүүлнэ. Газар нь салбарын бодлого, төлөвлөлт, хэрэгжилт, төсвийн зарцуулалтын тэнцвэр, харилцан уялдаа холбоог хангах асуудалд хууль тогтоомжийн хүрээнд өргөн хүрээтэй хандаж, зөв зохистой удирдаж зохицуулна.

Газар нь стандартчилал, тохирлын үнэлгээ, хэмжил зүй, сорьцын хяналтын хөгжлийг хурдасгах, олон улсын жишигт хүргэх, Монгол Улсын хөгжлийн чиг хандлагад нийцсэн экспортыг дэмжсэн үндэсний үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, үндсэн чиг үүргийнхээ хүрээнд чанартай, хүртээмжтэй үйлчилгээ үзүүлэх зэрэг асуудлыг хамарсан Засгийн газрын зөвлөхийн үүрэг, хариуцлага хүлээнэ.

1.6 Стратегийн удирдлага, зохицуулалтын хэрэгцээний эх үүсвэр

Газрын стратегийн удирдлага, зохицуулалтын хэрэгцээний эх үүсвэр, нэн ялангуяа үндсэн үйлчлүүлэгч буюу хэрэглэгчийг оновчтой, бүрэн тодорхойлох нь газрын үйл ажиллагааны стратегийг үндэслэл сайтай тогтооход чухал ач холбогдолтой. Энэ хэрэгцээний эх үүсвэрт дараах загварт оруулсан үйлчлүүлэгч буюу хэрэглэгч хамрагдана:

СТАНДАРТ, ХЭМЖИЛ ЗҮЙН ГАЗРЫН СТРАТЕГИЙН УДИРДЛАГА, ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭРЭГЦЭЭНИЙ ЭХ ҮҮСВЭР



Газрын үндсэн үйлчлүүлэгч буюу хэрэглэгч нь Монгол Улсын Шадар сайд, Шадар сайдын ажлын алба байна.

Газрын стратегийн удирдлага, зохицуулалт нь дээр дурдсан хэрэгцээний эх үүсвэр, үндсэн үйлчлүүлэгч буюу хэрэглэгчийн эрэлт хэрэгцээг хангахтай холбогдон үүсэх харилцааг зохицуулахад чиглэнэ.

Газрын стратегийн удирдлага, зохицуулалтын хэрэгцээг хангах үйлчилгээний хүрээ, төрөл, хэлбэрийг хэрэгцээний эх үүсвэр бүрээр тогтоон тус Газрын зохион байгуулалтын бүтцийн нэгжүүдийн зорилт, чиг үүрэг, төрийн албан хаагчдын ажлын байр /албан тушаал/-ны тодорхойлолтод тусгаж хэрэгжүүлнэ.

Хоёр.Стандарт, хэмжил зүйн газрын үйл ажиллагааны стратеги

2.1 Үйл ажиллагааны стратегийн мөн чанар

Газрын үйл ажиллагааны стратегийн мөн чанар нь Засгийн газрын үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл болон Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол Улсын Шадар сайдын эрхлэх асуудлын хүрээний стандартчилал, тохирлын үнэлгээ, хэмжил зүй, сорьцын хяналтын зорилт, чиг үүргийг хэрэгжүүлэхэд чиглэсэн өндөр мэргэшлийн, цаг үеэ олсон, шуурхай зөвлөгөө, бүх талын дэмжлэг үзүүлэхэд оршино.

2.2 Үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл

Газар нь дор дурдсан үйл ажиллагааны тэргүүлэх чиглэлтэй ажиллана:

2.2.1 Нийтийн ашиг сонирхол, хүний эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчин, улс орны аюулгүй байдлыг хамгаалах, үндэсний үйлдвэрлэл, бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний өрсөлдөх чадварыг дээшлүүлэхэд стандартчилал, тохирлын үнэлгээний техникийн зохицуулалтын үйл ажиллагаагаар дэмжлэг үзүүлэх;

2.2.2 Нийгэм, эдийн засгийн хөгжлийг хэмжлийн нэгдмэл байдлыг хангах бодлогоор дэмжих, Монгол Улсын хэмжлийн тогтолцоо, хэмжлийн нэгжийн үндэсний эталон, хууль эрхийн хэмжил зүйн техникийн чадавхыг нэмэгдүүлж олон улсын түвшинд хүргэх;

2.2.3 Олон улсын шаардлагад нийцсэн тохирлын үнэлгээний байгууллагын итгэмжлэлийн тогтолцоог бий болгох, эдийн засгийн чадавхыг дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлэх;

2.2.4 Бүтээгдэхүүн, үйлчилгээний болон удирдлагын тогтолцоо (ISO 9001, ISO 14000, HACCP)-ны баталгаажуулалтын үйл ажиллагаагаар худалдаа, үйлчилгээ, үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжих, тэдэнд зах зээл дээр шударга өрсөлдөх таатай нөхцлийг бүрдүүлэх;

2.2.5 Сорьцын баталгааг олон улсын түвшинд хүргэх, үнэт металлын сорьц тогтоох, эрдэнийн чулуу тодорхойлох үйлчилгээг олон улсын стандартын дагуу хийж хэрэглэгчдийн эрх ашигийг хамгаалах;

2.3 Үйл ажиллагааны зарчим

Газрын үйл ажиллагааны үндсэн зарчим нь Засгийн газрын агентлагын эрх зүйн байдлын тухай хуульд заасны дагуу Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан төрийн үйл ажиллагааны үндсэн зарчмаас гадна төрийн үйлчилгээг жигд, чанартай, шуурхай, хүртээмжтэй хүргэх, ил тод, мэргэшсэн байх,

хууль ёсыг сахих, үйл ажиллагааныхаа төлөө хариуцлага хүлээх зарчмыг баримтлах явдал мөн.

2.4 Үйл ажиллагааны эрхэм зорилго

Стандарт, хэмжил зүйн газрын эрхэм зорилго нь Монгол Улсын хөгжлийн стратеги чиг хандлагад нийцүүлэн улс орон, нийгэм, эдийн засгийн аюулгүй байдлыг хангаж, экспортыг нэмэгдүүлж, үндэсний үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд стандартчилал, хэмжил зүй, тохирлын үнэлгээ, сорьцын хяналтын бодлогоор дэмжлэг үзүүлэхэд оршино.

2.5 Үйл ажиллагааны стратегийн зорилт

Стандарт, хэмжил зүйн газар нь эрхэм зорилгодоо хүрэхийн тулд дараах стратегийн зорилтыг хэрэгжүүлнэ:

2.5.1 Төрийн захиргааны удирдлагыг хэрэгжүүлэх, зохицуулалтыг хангах, гадаад харилцаа, хамтын ажиллагааг эрхэлсэн асуудлаараа олон улс, бүс нутаг, гадаад орны хүрээнд өргөжүүлэх;

2.5.2 Стандартчилал, тохирлын үнэлгээ, хэмжлийн нэгдмэл байдлыг хангах хууль тогтоомжийг боловсронгуй болгоход санал боловсруулах, бодлого, стратегийг төлөвлөх, бодлогын удирдамжаар хангах, хэрэгжилтийг зохицуулах, гүйцэтгэлд хяналт-шинжилгээ үнэлгээ хийх;

2.5.3 Стандартчилал, тохирлын үнэлгээ, техникийн зохицуулалтын хөтөлбөр, төсөл боловсруулах, техникийн зохицуулалтыг олон улсын жишгээр бий болгоход дэмжлэг үзүүлэх, тэдгээрийн төсөлд шүүлт хийх, эдгээр чиглэлийн дүрэм журам, заавар, удирдамжаар хангах;

2.5.4 Хэмжлийн нэгжийн олон улсын системд тулгуурласан үндэсний эталоны тогтолцоог хөгжүүлэх, нарийвчлалыг олон улсын түвшинд ойртуулах, үндэсний эталоноос нэгж дамжуулах тогтолцоог сайжруулан бэхжүүлэх;

2.5.5 Итгэмжлэлийн бодлого боловсруулах, хэрэгжүүлэх, зохицуулалтыг хангах, олон улсын итгэмжлэлийн байгууллагаар итгэмжлүүлэх;

2.5.6 Сорьцын хяналтын тогтолцоог боловсронгуй болгох, сорьцын лабораторийн чадавхыг дээшлүүлэх;

2.5.7 Олон улсын гэрээ, хэлэлцээр, олон улс, бүс нутаг, гадаад орны болон үндэсний стандарт, тохирлын үнэлгээ, техникийн зохицуулалт болон холбогдох норматив-техникийн баримт бичгээс бүрдсэн үндэсний мэдээллийн сан бүхий төрийн мэдээллийн нөөц болох албыг байгуулан хөгжүүлэх;

2.5.8 Бүтээгдэхүүн, үйлчилгээ, тогтолцооны баталгаажуулалтыг олон улсын жишигт хүргэж хөгжүүлэх;

2.5.9 Хэмжих хэрэгслийн баталгаажуулалтыг улсын баталгаажуулалтад заавал хамрагдах хэмжих хэрэгслийн баталгаажуулалтын түвшинг дээшлүүлэх, баталгаажуулалтын ажлын чанарыг олон улсын түвшинд ойртуулах;

2.5.10 Хэмжих хэрэгслийн шалгалт, тохируулгын ажлын чанарыг зах зээлд хүртээмжтэйгээр олон улсын түвшинд хүргэх;

2.6 Үйл ажиллагааны гол зорилт

Стандарт, хэмжил зүйн газрын үйл ажиллагааны стратегийн зорилт тус бүрийн хүрээнд дор дурдсан үйл ажиллагааны гол зорилтыг дэвшүүлэн ажиллана:

2.6.1 Үйл ажиллагааны стратегийн 1 дүгээр зорилтын хүрээнд:

2.6.1.1 Төрийн захиргааны удирдлагын манлайллыг хангах, хөрөнгө санхүүгийн удирдлага, дотоод үйлчилгээгээр байгууллагын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх;

2.6.1.2 Салбарын хүний нөөцийн удирдлагын манлайллыг хангах, боловсон хүчнийг бэлтгэх, давтан сургах, мэргэшлийг нь дээшлүүлэх;

2.6.1.3 Салбарын гадаад харилцаа, хамтын ажиллагааг олон улс, бүс нутаг, гадаад орны түвшинд хөгжүүлэх, удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээ авах;

2.6.1.4 Хууль тогтоомж, Газрын даргын шийдвэрийн хэрэгжилтийг хангаж хяналт тавих, үндсэн нэгжүүдэд бүх талын зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх;

2.6.2 Үйл ажиллагааны стратегийн 2 дугаар зорилтын хүрээнд:

2.6.2.1 Стандартчилал, тохирлын үнэлгээний тухай хууль, хэмжлийн нэгдмэл байдлыг хангах хууль тогтоомжийг боловсронгуй болгох талаар хуульд нэмэлт өөрчлөлтийн тухай хуулийн төслийг боловсруулж хууль тогтоох байгууллагад уламжлах;

2.6.2.2 Стандартчилал, тохирлын үнэлгээ, хэмжлийн нэгдмэл байдлыг хангах, сорьцын хяналтын бодлого, стратегийг төлөвлөх, бодлогын удирдамжаар хангах, хэрэгжилтийг зохицуулах;

2.6.2.3 Салбарын эрх зүйн орчныг зохицуулах хууль тогтоомжтой нийцүүлэн холбогдох дүрэм, журмуудыг шинэчлэн сайжруулах;

2.6.3 Үйл ажиллагааны стратегийн 3 дугаар зорилтын хүрээнд:

2.6.3.1 Стандартчилал, тохирлын үнэлгээ, техникийн зохицуулалтын баримт бичгүүдийг олон улсын жишигт нийцүүлэн боловсронгуй болгох, үндэсний стандартад олон улсын стандартын түвшинд хүрсэн стандартын эзлэх хувийг нэмэгдүүлэх;

2.6.3.2 Шинэ үйлдвэрлэл, үйлчилгээ, дэвшилтэт технологи нэвтрүүлэхэд стандартчилал, тохирлын үнэлгээний бодлогоор байнгын дэмжлэг, туслалцаа үзүүлэх;

2.6.3.3 Олон улс, бүс нутаг, 2 талын стандартчилал, тохирлын үнэлгээний байгууллагуудын хамтын ажиллагааг хөгжүүлэх;

2.6.3.4 Стандартчиллын техникийн хороод болон дэд хороодын үйл ажиллагааг зохион байгуулах, зохицуулах, арга зүйгээр хангах;

2.6.4 Үйл ажиллагааны стратегийн 4 дүгээр зорилтын хүрээнд:

2.6.4.1 Хэмжлийн нэгжийн үндэсний эталоны тогтолцоог бүрдүүлэх стратеги, хөтөлбөр, төсөл боловсруулах, хэмжлийн нэгжийн шинэ эталон бий болгох, нэгж дамжуулалт, эталоны хадгалалтыг сайжруулах;

2.6.4.2 Байгууллага, үйлдвэр, аж ахуйн нэгжийн лабораторид ашиглагдаж байгаа өндөр нарийвчлал бүхий хэмжих хэрэгслийн баталгаажуулалт, шалгалт тохируулгын тогтолцоог бий болгож сайжруулах арга хэмжээг авах;

2.6.4.3 Хэмжилзүйн ажил, үйлчилгээний тусгай зөвшөөрөл олгох, хэмжих хэрэгслийн загварын туршилт хийх тогтолцоог олон улсын жишигт нийцүүлэн хялбаршуулах, боловсронгуй болгох;

2.6.4.4 Хэмжих хэрэгслийн шалгалт тохируулга, баталгаажуулалт, загварын туршилтын үр дүн, гэрчилгээг харилцан хүлээн зөвшөөрөх олон улсын хэлэлцээрүүдэд Монгол улс нэгдэн орох чиглэлээр олон улсын хэмжил зүйн байгууллагуудтай хамтран ажиллах;

2.6.5 Үйл ажиллагааны стратегийн 5 дугаар зорилтын хүрээнд:

2.6.5.1 Итгэмжлэлийн тогтолцоог боловсронгуй болгох чиглэлээр олон улсын төсөл, үндэсний хөтөлбөрийг боловсруулж, хэрэгжилт зохицуулалтыг хангах;

2.6.5.2 Итгэмжлэлийн байгууллагын маргаан шийдвэрлэх комисс, техникийн Зөвлөлүүдийн үйл ажиллагааг зохицуулах, нийтлэг арга зүйгээр хангах;

2.6.5.3 Үндэсний итгэмжлэгдсэн лабораториудын тогтолцоог бий болгох, мэргэжлийн удирдлага, арга зүйгээр хангах;

2.6.5.4 Итгэмжлэлийн ажил, үйлчилгээний хүрээг олон улсын тогтолцооны дагуу өргөтгөх, чанарыг хангах; /Бүтээгдэхүүн, үйлчилгээ, удирдлагын тогтолцооны баталгаажуулалтын байгууллага, техникийн хяналтын байгууллага, хяналтын баталгаажуулалт, клиник оношлогооны лабораторийг итгэмжлэх/

2.6.5.5 Дэлхийн худалдаан дахь техникийн саад тотгорыг арилгах, хөнгөвчлөх зорилгоор хоёр талт болон олон талт хэлэлцээр (MRA)-д нэгдэн орох чиглэлээр олон улсын байгууллагатай хамтран ажиллах;

2.6.5.6 Бүс нутгийн болон олон улсын лаборатори итгэмжлэлийн хамтын ажиллагааны байгууллагын техникийн хорооны ажилд тогтмол оролцох;

2.6.6 Үйл ажиллагааны стратегийн 6 дугаар зорилтын хүрээнд:

2.6.6.1 Үнэт металл, эрдэнийн чулууны үйлдвэрлэл, үйлчилгээг зохицуулсан эрх зүйн акт, сорьцын хяналтын тогтолцоог боловсронгуй болгох ажлыг зохион байгуулах, хэрэгжүүлэх;

2.6.6.2 Үнэт металл, эрдэнийн чулуу, тэдгээрээр хийсэн эдлэлд шинжилгээ хийж эрдэнийн чулууг таньж, металлын сорьцыг тогтоон улсын сорьцын баталгааны тэмдэг дарах буюу гэрчилгээ олгох;

2.6.6.3 Сорьцын баталгааны тэмдгийн хяналт шалгалтыг хийж хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах;

2.6.6.4 Үнэт металлыг хайлж гулдмайлах, сорьцын лабораторийн багаж хэрэгсэл, тоног төхөөрөмжийг сайжруулах;

2.6.7 Үйл ажиллагааны стратегийн 7 дугаар зорилтын хүрээнд:

2.6.7.1 Стандарт, тохирлын үнэлгээ, техникийн зохицуулалт, норматив баримт бичгийг олон нийтэд хүргэх, мэдээлэх, үйлчилгээ үзүүлэх, сурталчлах;

2.6.7.2 Стандарт, тохирлын үнэлгээ, техникийн зохицуулалт, норматив баримт бичгийн үндэсний мэдээллийн сан бүрдүүлэх, хадгалах, хамгаалах;

2.6.7.3 Салбарын мэргэжлийн боловсон хүчнийг бэлтгэх, давтан сургах, мэргэшлийг нь дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлэх;

2.6.7.4 Салбарын мэдээллийн технологийг хөгжүүлэх хүрээнд программ хангамж, техник хангамжийн асуудлыг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэх;

2.6.8 Үйл ажиллагааны стратегийн 8 дугаар зорилтын хүрээнд:

2.6.8.1 Бүтээгдэхүүн, үйлчилгээ, удирдлагын тогтолцооны баталгаажуулалтыг үндэсний болон олон улсын хууль, тогтоомж, стандартын шаардлагад нийцүүлэн хөгжүүлэх;

2.6.8.2 Бүтээгдэхүүн, үйлчилгээний тогтолцооны баталгаажуулалтын хамрах хүрээг өргөжүүлэх; /газар зүйн заалт, эко-бүтээгдэхүүн гэх мэт/

2.6.8.3 Тохирлын гэрчилгээ авсан бүтээгдэхүүний талаар хэрэглэгчдэд өргөнөөр сурталчлах ажлыг зохион байгуулах;

2.6.8.4 Баталгаажуулалтын үйл ажиллагааны талаарх хэрэглэгчдийн мэдлэгийг дээшлүүлэх улмаар тэдэнд зөв сонголт хийх, өөрийн үйл ажиллагаанд итгэх итгэлийг нэмэгдүүлэх нөхцөлийг бүрдүүлэх;

2.6.9 Үйл ажиллагааны стратегийн 9 дүгээр зорилтын хүрээнд:

2.6.9.1 Худалдаа үйлчилгээний тооцоо, эрүүл мэнд, байгаль орчин, улс орны аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаанд ашиглаж байгаа хэмжих хэрэгслийг улсын баталгаажуулалтад бүрэн хамруулах, хэмжих хэрэгслийн анхдагч болон түүвэр баталгаажуулалт, шалгалт тохируулгын тогтолцоог бий болгож сайжруулах арга хэмжээг авах;

2.6.9.2 Хэмжих хэрэгслийн баталгаажуулалт, шалгалт тохируулгад шаардлагатай эталоныг бий болгох, ажлын хэмжих хэрэгслийг шалгалт тохируулгын үйлчилгээнд хамруулах, эдгээр ажлын чанарыг дээшлүүлэхэд чиглэсэн хөрөнгө оруулалтын төсөл, хөтөлбөр боловсруулах, шийдвэрлүүлэх, хэрэгжилтийг зохион байгуулах;

2.6.9.3 Хэмжих хэрэгслийн баталгаажуулалтын үйл ажиллагааны талаарх хэрэглэгчдийн мэдлэгийг дээшлүүлэх улмаар тэдэнд зөв сонголт хийх, өөрийн үйл ажиллагаанд итгэх итгэлийг нэмэгдүүлэх нөхцөлийг бүрдүүлэх;


2.7 Үйл ажиллагааны зорилт

Газрын үйл ажиллагааны гол зорилт тус бүрийн хүрээнд тэдгээрийг хэрэгжүүлэхэд чиглэгдсэн үйл ажиллагааны зорилтыг тус газар тодорхойлж, зохион байгуулалтын бүтцийн нэгжүүдийн зорилт, чиг үүрэг, ажилтнуудын ажлын байр (албан тушаал)-ны тодорхойлолтод тусган хэрэгжүүлнэ.

2.8 Үйл ажиллагааны стратеги

Газрын үйл ажиллагаа (бизнес)-ны стратегийн загварыг дор дурдснаар тодорхойлж байна.

СТАНДАРТ, ХЭМЖИЛ ЗҮЙН ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ СТРАТЕГИЙН ЗАГВАР (БИЗНЕС) ТӨЛӨВЛӨГӨӨ



Стандарт, хэмжил зүйн газрын эрхэм зорилго нь Монгол Улсын стратеги хөгжлийн чиг хандлагад нийцүүлэн улс орон, нийгэм, эдийн засгийн аюулгүй байдлыг хангаж экспортын дэмжсэн үндэсний үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд стандартчилал, тохирлын үнэлгээ, хэмжил зүй, сорьцын бодлогоор дэмжлэг үзүүлэхэд оршино.

2.9 Үйл ажиллагааны хэтийн төлөвлөгөө

Газрын эрхэм зорилго, үйл ажиллагааны стратегийн зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны хэтийн төлөвлөгөөг боловсруулан баталж ажиллана. Газрын үйл ажиллагааны хэтийн төлөвлөгөө нь төсвийн ерөнхийлөн захирагч (Шадар сайд)-аас төсвийн шууд захирагч (Газрын дарга)-тай байгуулах үр дүнгийн гэрээний салшгүй хэсэг байна.

Гурав. Газрын үйл ажиллагааны бүтцийн ерөнхий тогтолцоо, зохион байгуулалтын бүтэц, тэдгээрийн үндсэн үүрэг, чиг үүрэг

3.1 Бүтцийн ерөнхий тогтолцоо боловсруулахад баримтлах зарчим

Газрын үйл ажиллагааны бүтцийн ерөнхий тогтолцоо, зохион байгуулалтын бүтцийг боловсруулахад дараах зарчмыг баримтлав:

3.1.1. Газрын стратегийн зорилтыг бүтцэд тусгасан байх зарчим (тухайн газрын бүтцийн ерөнхий тогтолцоо, зохион байгуулалтын бүтэц нь түүний үйл ажиллагааны стратегийн зорилттой уялдсан байх);

3.1.2. Эрх мэдлийн зааг ялгаа нь тодорхой, итгэл хүлээхүйц байх зарчим (бүтцийн нэгжүүд, тэдгээрийн удирдах албан тушаалын түвшин, нэр нь аль нэгж, ямар асуудал эрхэлдэг, аль албан тушаал, ямар эрх мэдэлтэй болохыг тодорхой мэдэж болохуйц байх, тэдгээрийн ажлын уялдаа, ажиллах чадвар нь итгэл хүлээхүйц байх, бусад байгууллагын зорилт, чиг үүрэгтэй давхардахгүй байх);

3.1.3. Үзэгдэхүйц үйлчилгээний болон стратегийн удирдлагын баримжаатай байх зарчим (газрын нэр, бүтцээс тухайн байгууллагын үйл ажиллагааны дүр төрх харагдахуйц байх);

3.1.4. Бүтцийн хувьд энгийн байх зарчим (газрын даргаас хамгийн доод нэгжээ хүртэл гурваас дээшгүй шат дамжлагатай байх);

3.1.5. Тэнцвэрийг хангах, хяналтын хүрээг тогтоох зарчим (газрын үйл ажиллагааны стратеги, бүтцийн зөв зохистой тэнцвэрийг хангах замаар аль болох хялбар удирдах, хянах боломжтой байх, үйл ажиллагааны стратегийн зорилтыг аль болохоор оновчтой бүлэглэх замаар бүтцийн ерөнхий тогтолцоог тогтоосон байх, энэ нь удирдлагын чиг үүрэг, хүн хүчний болон бусад нөөцийг зөв хуваарилан хэрэглэгчийнхээ хэрэгцээнд нийцсэн үйлчилгээ үзүүлэх боломж бүрдүүлсэн байх);


3.1.6. Улс төрийн хувьд төвийг сахисан байх зарчим (газрын төрийн захиргааны албан хаагч нь Монгол Улсын Шадар сайд, бусад үйлчлүүлэгч буюу хэрэглэгчид өндөр мэргэшлийн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх, улс төрийн аливаа нөлөөнд автахгүй, төвийг сахисан байх);

3.1.7. Хангалттай чадавх, бодитой үйл ажиллагааны зарчим (үйл ажиллагааны бүтцийн ерөнхий тогтолцооны загвар, зохион байгуулалтын бүтэц нь чадавхаа бүрэн дайчлан илрүүлэхэд чиглэсэн хэрэгжихүйц бөгөөд ажиллах чадвартай байх).

3.2 Үйл ажиллагааны бүтцийн ерөнхий тогтолцооны загвар

Дээр дурьдсан зарчим болон газрын үйл ажиллагаа (бизнес)-ны стратегийн загварыг үндэслэн Газрын үйл ажиллагааны бүтцийн ерөнхий тогтолцооны дараах загварыг санал болгож байна.

СТАНДАРТ, ХЭМЖИЛ ЗҮЙН ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БҮТЦИЙН ЕРӨНХИЙ ТОГТОЛЦООНЫ ЗАГВАР



3.3 Зохион байгуулалтын бүтэц

Газрын үйл ажиллагааны стратегийн болон бүтцийн ерөнхий тогтолцооны загварыг үндэслэн тус байгууллагын зохион байгуулалтын бүтэц, тэдгээрийн үндсэн үүрэг, чиг үүргийг дор дурдсанаар тодорхойлж байна.

3.3.1 Төрийн захиргааны удирдлагын асуудал хариуцсан зохион байгуулалтын бүтцийн нэгжийн үндсэн үүрэг, чиг үүрэг:

Энэ нэгж нь үйл ажиллагааны стратегийн 1 дүгээр зорилтын хүрээнд төрийн захиргааны удирдлагын болон хүний нөөцийн манлайллыг хангах, газрын удирдлага, зохион байгуулалтын бүтцийн нэгжийн удирдлага, ажилтнуудад эрх зүйн зөвлөгөө болон дотоод дэмжлэг, үйлчилгээ үзүүлэх, удирдлага болон ажилтнуудын чадавхыг дээшлүүлэх, тэдний үйл ажиллагаа, мэргэшлийн түвшинг үнэлж дүгнэх, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах чиг үүрэг хэрэгжүүлнэ.

Энэ нэгж нь газрын санхүү, аж ахуйн үйл ажиллагааг хэрэгжүүлэх, хүний нөөцийн бэлэн байдлыг хангах, стандартчилал, тохирлын үнэлгээ, хэмжил зүй, сорьцын хяналтын асуудлаар олон улсын байгууллагад гишүүнээр элсэх, олон улс болон бүс нутаг, гадаадын холбогдох байгууллагатай хамтын ажиллагааг хөгжүүлэх, хэмжил зүй, тохирлын үнэлгээний үр дүнг харилцан хүлээн зөвшөөрөхөд дэмжлэг үзүүлэх, зохицуулах асуудлыг мөн хэрэгжүүлнэ.

Энэ нэгжийн үйл ажиллагаа нь цомхон, чадварлаг, төрийн албан хаагч бүхий мэргэшсэн хүний нөөцөөр газрын тасралтгүй, хэвийн, жигд ажиллагааг хангахад чиглэнэ. Энэ нь газрын даргаас шийдвэр боловсруулан гаргах, хэрэгжүүлэхэд эрх зүйн болон бусад дэмжлэг үзүүлэх, шаардлагатай дэмжлэгээр хангах замаар хэрэгжинэ.

Энэ нэгжээс үзүүлэх үйлчилгээний үндсэн хэрэглэгч нь Газрын удирдлага, зохион байгуулалтын бүтцийн нэгжүүд, ажилтнууд байх бөгөөд шууд бус хэрэглэгч нь орон нутгийн стандартчилал, хэмжил зүйн байгууллага, аж ахуйн нэгж байгууллага, иргэд байна. Үйлчилгээг үзүүлэх оролцогч гол түнш нь төрийн албаны төв болон салбар зөвлөл, Шадар сайдын ажлын алба болон холбогдох байгууллага байна.

3.3.2 Стратегийн бодлого, төлөвлөлт, дотоод аудитын асуудал хариуцсан зохион байгуулалтын бүтцийн нэгжийн үндсэн үүрэг, чиг үүрэг:

Энэ нэгж нь үйл ажиллагааны стратегийн 2 дугаар зорилтын хүрээнд стратегийн төлөвлөлт хийх, нэгдсэн бодлогыг боловсруулах, хууль тогтоомж, Дээд байгууллагын шийдвэрийн биелэлтэд хяналт тавих, бодлого, хөтөлбөр, төслийн хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ хийж, үр дүн өгөөжийг тодорхойлох, удирдлагыг үнэн зөв, бодит мэдээллээр хангана;

Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх Үндсэн чиглэлд Стандартчилал, тохирлын үнэлгээ, хэмжил зүй, сорьцын хяналтын чиглэлээр тусгагдсан арга хэмжээний гүйцэтгэлд байнгын хяналт тавьж, хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийх, үр дүнг үнэлэхээс гадна гадаадын зээл, тусламж, 2 талын хамтын ажиллагааны хүрээнд болон дотоодын хөрөнгө оруулалтаар гүйцэтгэн хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрийг холбогдох нэгжүүдтэй хамтран боловсруулж, хэрэгжилтийг хангуулна;

Энэ нэгж нь газрын үйл ажиллагааны хэтийн төлөвлөгөө, нэгдсэн төлөвлөлт, газрын даргын төсвийн Ерөнхийлөн захирагчтай байгуулах үр дүнгийн гэрээ, түүнийг хэрэгжүүлэх төлөвлөгөө боловсруулж, тэдгээрийн хэрэгжилтэд хяналт тавих, сайжруулах арга хэмжээг төлөвлөнө;

Зохион байгуулалтын үндсэн нэгж болон орон нутгийн Стандартчилал, хэмжил зүйн хэлтсийн үйл ажиллагааны бүтээгдэхүүн нийлүүлэх болон Ерөнхий менежерээс Төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан бүтээгдэхүүн нийлүүлэх гэрээний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийх, үр дүнг нэгтгэн үнэлж дүгнэх чиг үүргийг хүлээж, Газрын даргын шууд удирдлаган дор үйл ажиллагаагаа явуулах бөгөөд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх чиг үүргийг бие даасан, хараат бус, ил тод, хууль дээдлэх зарчим баримтлан явуулна.

Энэ нэгжээс үзүүлэх үйлчилгээний үндсэн хэрэглэгч нь Шадар сайд, түүний ажлын алба, Агентлагийн дарга, дэд дарга, үндсэн нэгжийн дарга, шууд бус хэрэглэгч нь орон нутгийн стандартчилал, хэмжил зүйн хэлтэс, аж ахуйн нэгж, хэвлэл мэдээллийн болон төрийн бус байгууллага, иргэд байна. Энэ үйлчилгээг үзүүлэхэд оролцох гол түнш нь зохион байгуулалтын үндсэн нэгжүүд байна.

3.3.3 Стандартчилал, тохирлын үнэлгээний бодлогын асуудал хариуцсан зохион байгуулалтын бүтцийн нэгжийн үндсэн үүрэг, чиг үүрэг:

Энэ нэгж нь үйл ажиллагааны стратегийн 3 дугаар зорилтын хүрээнд стандартчилал, тохирлын үнэлгээний тухай хууль тогтоомжийг боловсронгуй болгох талаар санал боловсруулах, бодлого, стратегийг төлөвлөх, удирдамжаар хангах, хэрэгжилтийг зохицуулах, стандартчилал, тохирлын үнэлгээ, техникийн зохицуулалтын баримт бичгүүдийг олон улсын жишигт нийцүүлэн боловсронгуй болгох, үндэсний стандартад олон улсын стандартын түвшинд хүргэж нэмэгдүүлэх, шинэ үйлдвэрлэл, үйлчилгээ, дэвшилтэт технологи нэвтрүүлэхэд стандартчиллын бодлогоор байнгын дэмжлэг, туслалцаа үзүүлэх, олон улс, бүс нутаг, 2 талын стандартчиллын хамтын ажиллагааг хөгжүүлэх, стандартчиллын техникийн хороод болон дэд хороодын үйл ажиллагааг зохион байгуулах, зохицуулах, стандартчилалын үндэсний зөвлөлийн үйл ажиллагаанд мэргэжил, аргагүйн дэмжлэг үзүүлэх чиг үүрэг хэрэгжүүлнэ.

Чанарын дэд бүтэц, хөтөлбөрийн хүрээнд хийгдэх ажлын уялдааг хангаж зохицуулна.

Энэ нэгжээс үзүүлэх үйлчилгээний үндсэн хэрэглэгч нь яам, агентлаг, төрийн бус болон хувийн хэвшлийн байгууллага, хяналт үнэлгээний байгууллага, эрдэм шинжилгээ, судалгааны байгууллага, олон улсын болон гадаадын байгууллага, иргэд байна.

3.3.4 Хэмжил зүйн хүрээлэн эрхэлсэн зохион байгуулалтын бүтцийн нэгжийн үндсэн үүрэг, чиг үүрэг:

Энэ нэгж нь үйл ажиллагааны стратегийн 4 дүгээр зорилтын хүрээнд хэмжлийн нэгдмэл байдлыг хангах тухай хууль, эрх зүйн орчинг олон улсын жишиг, улс орны нийгэм эдийн засгийн шаардлагад нийцүүлэн боловсронгуй болгох санал боловсруулах, тэдгээрийг хэрэгжүүлэх, хэмжлийн нэгдмэл байдлыг хангах бодлого, хэтийн чиглэл, хөтөлбөр боловсруулах, хууль эрхийн хэмжил зүй, үйлдвэрлэлийн хэмжил зүйг хөгжүүлэх, мэргэжил арга зүйн удирдлагаар хангах, хэмжил зүйн ажил, үйлчилгээний тусгай зөвшөөрөл олгох, хэмжих хэрэгслийн загварын туршилт хийх тогтолцоог олон улсын жишигт нийцүүлэн хялбаршуулах, боловсронгуй болгох, хэмжлийн нэгжийн үндэсний эталоны тогтолцоог бүрдүүлэх стратеги, хөтөлбөр, төсөл боловсруулах, хэмжлийн нэгжийн эталоныг бий болгох, хадгалах, бүртгэх, нэгж дамжуулах, хэмжлийн нэгжийн эталоны ашиглалт, хөтлөлтийн чиглэлээр судалгаа шинжилгээний ажлыг эталоны нэгдсэн лаборатори, секторын тогтолцоонд үндэслэн хийх, хэмжил зүйн олон улсын байгууллага, хэлэлцээрт нэгдэн орох, тэдгээртэй хамтран ажиллах чиг үүрэг хэрэгжүүлнэ.

Энэ нэгжээс үзүүлэх үйлчилгээний үндсэн хэрэглэгч нь шинжлэх ухаан, эрдэм шинжилгээний байгууллага, их дээд сургууль, хэмжил зүйн тусгай зөвшөөрөл бүхий байгууллага, аливаа хэрэглэгчтэй материал баялаг, эрдэс, түүхий эд, бүтээгдэхүүнийг үйлдвэрлэж борлуулж байгаа бүх хэвшлийн аж ахуйн нэгж байгууллага, иргэд байна. Энэ үйлчилгээг үзүүлэхэд оролцох гол түнш газрын зохион байгуулалтын нэгжүүд, төрийн болон хувийн хэвшлийн аж ахуйн нэгж байна.

3.3.5 Итгэмжлэлийн асуудал хариуцсан зохион байгуулалтын бүтцийн нэгжийн үндсэн үүрэг, чиг үүрэг:

Энэ нэгж нь үйл ажиллагааны стратегийн 5 дугаар зорилтын хүрээнд итгэмжлэлийн тогтолцоог боловсронгуй болгох чиглэлээр олон улсын төсөл, үндэсний хөтөлбөрийг боловсруулж, хэрэгжилт зохицуулалтыг хангах, итгэмжлэлийн байгууллагын маргаан шийдвэрлэх комисс, техникийн Зөвлөлүүдийн үйл ажиллагааг зохицуулах, нийтлэг арга зүйгээр хангах, үндэсний итгэмжлэгдсэн лабораториудын тогтолцоог бий болгох, мэргэжлийн удирдлага, арга зүйгээр хангах, итгэмжлэлийн ажил, үйлчилгээний хүрээг олон улсын тогтолцооны дагуу өргөтгөх, чанарыг хангах, бүс нутгийн болон олон улсын лаборатори итгэмжлэлийн хамтын ажиллагааны байгууллагын техникийн хорооны ажилд тогтмол оролцох, дэлхийн худалдааны байгууллагаас гаргасан "Нэг стандарт-нэг тохирлын үнэлгээ-нэг итгэмжлэл" уриан дор итгэмжлэлээр дамжуулан тохирлын үнэлгээний байгууллагуудын үр дүнг давтан гүйцэтгэхгүйгээр харилцан зөвшөөрөх олон улсын хэлэлцээр (MRA)-т нэгдэн орох, улс орны нийгэм, эдийн засгийн хөгжилд дэмжлэг үзүүлэх, ажил үйлчилгээнд нэг цэгийн үйлчилгээний зарчмыг нэвтрүүлэх.

Энэ нэгжээс үзүүлэх үйлчилгээний үндсэн хэрэглэгч нь Газрын зохион байгуулалтын нэгж, төрийн болон төрийн бус байгууллага, хяналт үнэлгээний байгууллагууд, эрдэм шинжилгээ, судалгаа хөгжлийн байгууллага, бизнес эрхлэгчид, аж ахуйн нэгж, олон нийтийн байгууллага, олон улсын болон гадаадын түнш байгууллага, иргэд байна.

3.3.6 Үнэт металлын сорьцын хяналтын асуудал хариуцсан зохион байгуулалтын бүтцийн нэгжийн үндсэн үүрэг, чиг үүрэг:

Энэ нэгж нь үйл ажиллагааны стратегийн 6 дугаар зорилтын хүрээнд үнэт металл, эрдэнийн чулууны үйлдвэрлэл, үйлчилгээг зохицуулсан эрх зүйн акт, сорьцын хяналтын тогтолцоог боловсронгуй болгох ажлыг зохион байгуулах, хэрэгжүүлэх, үнэт металл, тэдгээрээр хийсэн эдлэлд химийн шинжилгээ хийж металлын сорьцыг тогтоон

улсын сорьцын баталгааны тэмдэг дарах, эрдэнийн чулууг таньж гэрчилгээ гэрчилгээ олгох, сорьцын баталгааны тэмдгийн хяналт шалгалтыг хийж сорьцтой холбоотой маргааныг таслан шийдвэрлэх шинжилгээ хийж хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах, үнэт металлыг хайлж гулдмайлах, сорьцын лабораторийн чадавхыг дээшлүүлэх чиг үүрэг хэрэгжүүлнэ.

Энэ нэгжээс үзүүлэх үйлчилгээний үндсэн хэрэглэгч нь үнэт металлын үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлдэг аж ахуйн нэгж байгууллага, иргэд байна. Энэ үйлчилгээг үзүүлэхэд оролцох гол түнш нь газрын зохион байгуулалтын бүтцийн нэгжүүд, төрийн хяналт шалгалтын байгууллага болон хувийн хэвшлийн аж ахуйн нэгж байгууллага, иргэд байна.

3.3.7 Стандартын мэдээлэл, лавлагаа, сургалт хариуцсан зохион байгуулалтын бүтцийн нэгжийн үндсэн үүрэг, чиг үүрэг:

Энэ нэгж нь үйл ажиллагааны стратегийн 7 дугаар зорилтын хүрээнд Олон улсын гэрээ хэлэлцээр, олон улс, бүс нутаг, гадаад орны болон үндэсний стандарт, техникийн зохицуулалт, удирдамж, зөвлөмж, аргачлал, заавар, тохирлын үнэлгээний журам болон холбогдох норматив-техникийн бусад баримт бичгийг хүлээн авах, бүртгэх, хадгалах, хамгаалах, олон нийтэд хүргэх, мэдээлэх, хэвлэх, борлуулах үйлчилгээ үзүүлэх, төрөлжсөн сургалт зохион байгуулах замаар салбарын боловсон хүчнийг бэлтгэх, давтан сургах, мэргэшлийг нь дээшлүүлэх, салбарын мэдээллийн технологийг хөгжүүлэх, программ хангамж, техник хангамжийг сайжруулах ажлыг зохион байгуулах, уялдуулан зохицуулах чиг үүрэг хүлээнэ.

Энэ нэгжээс үзүүлэх үйлчилгээний үндсэн хэрэглэгч нь газрын удирдлага, зохион байгуулалтын бүтцийн нэгжүүд ажилтнууд байх бөгөөд шууд бус хэрэглэгч нь орон нутгийн стандарт, хэмжил зүйн байгууллага, аж ахуйн нэгж байгууллага, иргэд байна. Энэ үйлчилгээг үзүүлэхэд оролцох гол түнш нь зохион байгуулалтын үндсэн нэгжүүд байна.

Энэ нэгж нь Засгийн газрын агентлагийн газрын даргын албан тушаалын ангилал, зэрэглэлд дүйцсэн байна.

3.3.8 Бүтээгдэхүүн, тогтолцооны баталгаажуулалтын асуудал хариуцсан зохион байгуулалтын бүтцийн нэгжийн үндсэн үүрэг, чиг үүрэг:

Энэ нэгж нь үйл ажиллагааны стратегийн 8 дугаар зорилтын хүрээнд баталгаажуулалт, тохирлын үнэлгээ, удирдлагын тогтолцооны талаар бодлого, хөтөлбөр, төсөл боловсруулах, хэрэгжилтийг зохицуулах, бүтээгдэхүүн, үйлчилгээ, удирдлагын тогтолцооны баталгаажуулалтыг үндэсний болон олон улсын хууль, тогтоомж, стандартын шаардлагад нийцүүлэн хөгжүүлэх, баталгаажуулалтын хамрах хүрээг өргөжүүлэх, тохирлын гэрчилгээ авсан бүтээгдэхүүний талаар хэрэглэгчдэд өргөнөөр сурталчлах ажлыг зохион байгуулах, баталгаажуулалтын үйл ажиллагааны талаарх хэрэглэгчдийн мэдлэгийг дээшлүүлэх улмаар тэдэнд зөв сонголт хийх, өөрийн үйл ажиллагаанд итгэх итгэлийг нэмэгдүүлэх нөхцлийг бүрдүүлэх;

Энэ нэгжийн үйл ажиллагаа нь заавал баталгаажуулалтад хамрагдах бүтээгдэхүүн, үйлчилгээний хамрах хүрээг өргөтгөх, тогтолцооны баталгаажуулалтыг байгаль орчин, хөдөлмөрийн аюулгүй байдал, үйлдвэрлэлийн чиглэлээр өргөжүүлэх, орон тооны бус шинжээчдийн чадавхыг сайжруулах, үндэсний итгэмжлэлийн байгууллагаар итгэмжлэгдэх замаар хэрэгжинэ.

Энэ нэгжээс үзүүлэх үндсэн хэрэглэгч нь төрийн болон хувийн хэвшлийн аж ахуйн нэгж байгууллага, иргэд байна. Энэ нэгжийн үйлчилгээг үзүүлэхэд оролцох гол түнш нь газрын зохион байгуулалтын бүтцийн нэгжүүд, төрийн болон хувийн хэвшлийн аж ахуйн нэгж байгууллага, иргэд байна.

3.3.9. Хэмжих хэрэгслийн шалгалт, баталгаажуулалтын асуудал хариуцсан зохион байгуулалтын бүтцийн нэгжийн үндсэн үүрэг, чиг үүрэг:

Энэ нэгж нь үйл ажиллагааны стратегийн 9 дүгээр зорилтын хүрээнд Хэмжлийн нэгдмэл байдлыг хангах хууль, эрх зүйн орчныг хэрэгжүүлэх, хэмжил зүйн төрийн хяналт шалгалтыг хэрэгжүүлэхэд оролцох, улсын баталгаажуулалтад заавал хамрагдах хэмжих хэрэгслийн баталгаажуулалт, шалгалт тохируулгад шаардлагатай ажлын эталоныг бий болгох, нарийвчлалыг дээшлүүлэхэд чиглэсэн хөрөнгө оруулалтын төсөл, хөтөлбөр, боловсруулах, шийдвэрлүүлэх, хэрэгжилтийг зохион байгуулах, хэмжил зүйн олон улсын байгууллага, хэлэлцээрт нэгдэн орох, тэдгээртэй хамтран ажиллах, худалдаа үйлчилгээний тооцоо, эрүүл мэнд, байгаль орчин, улс орны аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаанд ашиглаж байгаа хэмжих хэрэгслийг улсын баталгаажуулалтад бүрэн хамруулах, хэмжих хэрэгслийн анхдагч болон түүвэр баталгаажуулалт, шалгалт тохируулгын ажлын хамрах хүрээг ээлж дараатай өргөтгөх замаар зах зээлд нийлүүлэгдэж буй хэмжих хэрэгслийн шалгалт тохируулга гүйцэтгэх чадавхыг дээшлүүлнэ.

Энэ нэгжийн зохион байгуулалтын бүтцэд Хэмжих хэрэгслийн шалгалт тохируулгын асуудал хариуцсан нэгжийг ажиллуулж, удирдан чиглүүлж, гүйцэтгэлд нь хяналт тавин ажиллана.

Энэ нэгж нь үйл ажиллагааны стратеги зорилтын хүрээнд Хэмжлийн нэгдмэл байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилтийг хангах, орон нутгийн хэмжээнд хэмжих хэрэгслийг шалгалт тохируулгын ажлыг эрхлэн гүйцэтгэх, эдгээр ажлын чанарыг сайжруулахад арга зүйн удирдлагаар хангана.

Энэ нэгжээс үзүүлэх үйлчилгээний үндсэн хэрэглэгч нь шинжлэх ухаан, эрдэм шинжилгээний байгууллага, их дээд сургууль, хэмжил зүйн тусгай зөвшөөрөл бүхий байгууллага, аливаа хэрэглэгчтэй материал баялаг, эрдэс, түүхий эд, бүтээгдэхүүнийг үйлдвэрлэж борлуулж байгаа бүх хэвшлийн аж ахуйн нэгж байгууллага, иргэд байна. Энэ үйлчилгээг үзүүлэхэд оролцох гол түнш газрын зохион байгуулалтын нэгжүүд, төрийн болон хувийн хэвшлийн аж ахуйн нэгж байна.

Монгол Улсын Шадар сайдын
2016 оны 28 дугаар тушаалын
хоёрдугаар хавсралт

Стандарт, хэмжил зүйн газрын зохион байгуулалтын бүтэц

